



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.5, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Улсын байцаагчийн 2020 оны 06/384/1302 дугаар дүгнэлтээр бүхэлдээ ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон 61,607,070.00 (жаран нэгэн сая зургаан зуун долоон мянга далан) төгрөгийн балансын үнэ, 9,626,104.66 (есөн сая зургаан зуун хорин зургаан мянга нэг зуун дөрвөн төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын төв лабораторийн захирал Ц.Гантөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, ашиглаж болох материалыг ялган тоолж, үнэ тогтоон бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, Хан-Уул дүүрэгт байрлах газар эзэмших эрхийн гэрчилгээний 0044094, нэгж талбарын 8041/0224 дугаар бүхий 4360 м.кв газрыг байгууллагын эзэмшилд зориулалтын дагуу эм, био бэлдмэлийн чанарыг баталгаажуулах зориулалтаар ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
газрын 2020 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Халдваргүй малын байр	1973.01.01	61,607,070.00	9,626,104.66	51,980,965.34
Нийт дүн			61,607,070.00	9,626,104.66	51,980,965.34
			(жаран нэгэн сая зургаан зуун долоон мянга далан)	(есөн сая зургаан зуун хорин зургаан мянга нэг зуун дөрвөн төгрөг жаран зургаан мөнгө)	(тавин нэгэн сая есөн зуун наян мянга есөн зуун жаран таван төгрөг гучин дөрвөн мөнгө)